



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/96

Улаанбаатар хот

Г.Амьсгалын замын халдвар хүндрэлээс
сэргийлэх төв байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Шадар сайдын 2023 оны "Журам шинэчлэн батлах тухай" 28 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Журам заавар батлах тухай" А/373, 2022 оны А/528 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт, Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах тухай 2024 оны А/359 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Амьсгалын замын халдвар хүндрэлээс сэргийлэх төвийн эрсдэл харилцаа холбооны багийн бүрэлдэхүүн, чиг үүргийг нэгдүгээр, Хариу арга хэмжээний багийн бүрэлдэхүүн, чиг үүргийг хоёрдугаар, Төлөвлөлтийн багийн бүрэлдэхүүн, чиг үүргийг гуравдугаар, Санхүү, ложистик, нөөц зохицуулалтын багийн бүрэлдэхүүн, чиг үүргийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Тохиолдлын удирдлагын багуудыг удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн орлогч дарга (Г.Адьяа)-д даалгасугай.

3. Тохиолдлын удирдлагын багууд чиг үүргийнхээ дагуу үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг багуудын ахлагч нарт үүрэг болгосугай.

4. Томуу, Томуу төст өвчинтэй тэмцэх сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангахад шаардлагатай зардлыг гаргах, багуудын эмч, мэргэжилтнүүдийн илүү цагийн хөлсийг бодож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Б.Мягмарсүрэн)-д зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ эрхэлсэн орлогч даргад даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.НАРАНБААТАР



Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2024 оны 11 дугаар сарын 12-ны өдрийн
11.92 дугаар тушаалын 17 хавсралт

ЭРСДЛИЙН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар
Багийн ахлагч	С.Жаргалзаяа	Чанарын менежер	99061026
Гишүүд	Д.Мөнхзаяа	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан	88706009
	А.Амартөвшин	Мэдээлэл технологийн албаны дарга	99441206
	Б.Золзаяа	Хэвлэл мэдээллийн ажилтан	99956050

ЭРСДЛИЙН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ БАГИЙН ЧИГ ҮҮРЭГ

1. Эрсдэлийн харилцааны багийн дарга нь үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, Тохиолдлын удирдлагын багийн даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.
2. Эрсдэлийн харилцааны баг нь Томуу, томуу төст өвчин, Амьсгалын замын цочмог хүнд халдвараас урьдчилан сэргийлэх, өвчлөл, нас баралтын тоо, дэгдэлтийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний талаар үнэн зөв мэдээллийг мэргэжлийн багуудаас цаг тухайд нь авч, мэдээлэл бэлтгэн иргэд, хамтран ажиллагч байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудад шуурхай мэдээлэх үүрэгтэй.
3. Томуу, томуу төст өвчин, Амьсгалын замын цочмог хүнд халдварын тархалтын түвшин "Идэвхжлийн үе"-д шилжсэн хугацаанаас эхлээд "Улирал хоорондын түвшин"-д хүртэл томуу төст өвчинтэй холбоотой бүхий л сэдвээр иргэд, хамтран ажиллагч байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд хэвлэлийн мэдээ, зурагт хуудас, богино хэмжээний кино гэх мэт тохиромжтой бүх хэлбэрээр бэлтгэн түгээнэ.
4. Томуу, томуу төст өвчин, Амьсгалын замын цочмог хүнд халдварын тархалтын түвшин "Улирал хоорондын үе"-д байхад олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага, цахим хуудас, телевиз, радио болон хэвлэлийн байгууллагуудтай гэрээ хийж, мэдээлэл түгээх сувгийг тодорхой болгож, бэлэн байдлыг хангасан байна.
5. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй томуу төст өвчинтэй холбоотой мэдээллийг тандан судалж, худал, ташаа мэдээллийг залруулах, иргэдийн мэдээллийн хэрэгцээнд тохирсон мэдээллийг бэлтгэн түгээх ажлыг зохион байгуулна.
6. Иргэдийн онцлогт тохирсон мэдээлэл хүргэх стратегийг боловсруулж, тохиолдлын удирдлагын багийн даргаар батлуулж, ажиллана.
7. Улирлын томуугийн эсрэг дархлуужуулалтын талаар мэдээлэл бэлтгэж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр ажлыг зохион байгуулна.

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2024 оны 11 дугаар сарын 12-ны өдрийн
4/02 дугаар тушаалын...-р хавсралт



ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар
Багийн ахлагч	С.Өлзийжаргал	Тархвар судлаач	91071229
Гишүүд	Б.Намуунбайгаль	ХАЯТТ эрхлэгч	99102265
	Д.Молор-Эрдэнэ	Амбулаторийн эрхлэгч	99201688
	Ө.Ариунжаргал	Тархвар судлаач	86248628
	Б.Оргилмаа	Лабораторийн эмч	88079419
	А.Түвшинтогтох	Тархвар судлаач	95430300

ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ БАГИЙН ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ

1. Хариу арга хэмжээний баг нь Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед эрүүл мэндийн нөөцийг ашиглан дараах үйл ажиллагааг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.
2. Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтыг зохион байгуулна.
3. Өвчтөний эмнэлзүйн менежментийн чиглэлээр заавар, зөвлөмж эрүүл мэндийн төв болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч мэргэжилтнүүдэд сургалт мэдээлэл өгч дэмжлэг үзүүлнэ.
4. Амьсгалын замын өвчний тархварзүй, вирус судлал, эмнэлзүйн чиглэлээр томуугийн тандалт судалгааны эргэн мэдээлэл, молекул биологийн лабораторид хийгдэж байгаа шинжилгээний дүгнэлтийн талаар тандалт судалгаа хийж, Тохиолдлын удирдлагын багийн дарга, төлөвлөлтийн баг болон бусад мэргэжлийн багуудыг мэдээллээр хангана.
5. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн голомтонд хариу арга хэмжээ шуурхай зохион байгуулж, хүн амын дунд халдварын тархалтыг бууруулах, эрсдэлт бүлгийн хүн амыг хүндрэх, нас барахаас сэргийлэх, халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ЧИГ ҮҮРЭГ

1. Улирлын томуугийн эсрэг вакцинаар эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулах ажлыг зохион байгуулна.
2. Вакциныг цаг тухайд нь худалдан авах, нийлүүлэх, түгээх, ложистикийг үндэсний болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулна.
3. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед товлолын дархлаажуулалтын тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллана.
4. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн тандалтыг зохион байгуулж, мэдээг Тархвар судлалын тандалтын багт тухай бүрт хүргүүлнэ.
5. Дархлаажуулалтын мэдээг дархлаажуулалтыг хийж дуусах хүртэл хариуцан авч, Тархвар судлалын тандалтын багт хүргүүлнэ.
6. Дархлаажуулалттай холбоотой үүссэн аливаа асуудлыг Хариу арга хэмжээний багийн даргад танилцуулж, шуурхай шийдвэрлүүлнэ.
7. Дархлаажуулалтын үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай хүний болон эд материалын нөөцийн тооцоог гаргаж Хариу арга хэмжээний багийн даргад танилцуулж, шийдвэрлүүлнэ.

ТАРХВАР СУДЛАЛ ТАНДАЛТЫН ҮҮРЭГ

1. Жилийн турш өвчлөлийн хөдлөлзүй, вирус судлал, эмнэлзүйд гарч буй өөрчлөлтийг үйл явдалд суурилсан болон Томуугийн харуулдан тандалтын тогтолцоогоор хянаж, Өрхийн эрүүл мэндийн төвүүдээс тархалтын үе шатаас хамааруулж нэмэлт тоон мэдээг цуглуулж, нэгтгэн дүн шинжилгээ хийж, хянана.
2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлыг үүсгэж болзошгүй үйл явдлыг илрүүлэх, гэнэтийн шинж чанартай дэгдэлт, шалтгаан тодорхойгүй голомтолсон өвчлөл бүртгэгдэх тохиолдолд ШС-ын 28 дугаар тушаалын дагуу холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан тусгайлсан эрсдэлийн үнэлгээг хийнэ.
3. Хариу арга хэмжээний багийн дарга болон бусад багуудыг холбогдох мэдээллээр шуурхай хангаж, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах нөхцөлөөр хангана.
4. Аливаа тоон мэдээ, дүн шинжилгээ, тайлан, эрсдэлийн үнэлгээний дүн зэргийг Хариу арга хэмжээний багийн даргаар хянуулж, баталгаажуулсны дараа холбогдох мэргэжлийн багийн дарга, мэргэжилтнүүдэд хүргүүлнэ.

ЭМНЭЛЗҮЙН ЧИГ ҮҮРЭГ

1. Томуу, томуу тест өвчин, Амьсгалын замын цочмог хүнд халдварын дэгдэлтийн үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шуурхай, тасралтгүй үзүүлэх чадавхийн бэлэн байдлыг хангах, бэхжүүлэх чиглэлээр үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллана.
2. Тусгаарлах өрөөг стандартын шаардлагын дагуу зохион байгуулж, хүний нөөцийн хүрэлцээ, нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн судалгааг гаргаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангана.
3. Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал/үйл явдлын хариу арга хэмжээний үед эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх зураглал, шаардлагатай хүний нөөцийг чадавхжуулах, хэрэгжилтийг хангах, зохицуулах
4. Хэвтэн эмчлүүлэх шаардлагатай тусламж үйлчилгээний хүртээмж, тасралтгүй байдлыг хангаж ажиллах
5. Шаардлагатай, зохистой тусламж үйлчилгээг цаг тухайд нь авах боломжийг бүрдүүлэхийн тулд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хэрхэн хэзээ хаанаас авах зураглал (pathway)-ыг тодорхойлж/ боловсруулж, мөрдүүлэх

ЛАБОРАТОРЫН ЧИГ ҮҮРЭГ

1. Томуугийн улиралд вирус судлалын шинжилгээнд шаардлагатай хүний нөөц, урвалж, оношлуур, сорьц тээвэрлэх орчин, лабораторийн хэрэгсэл, сорьц тээвэрлэх тээврийн зардлын тооцоо зэргийг гаргаж хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана.
2. Холбогдох тасаг нэгжүүд болон өрхийн эрүүл мэндийн төвүүдээс шинжилгээний сорьцуудыг хүлээн авч шинжлэн, эргэн мэдээллээр хангаж ажиллах
3. Вирус судлалын лабораторийн шинжилгээнд тохирсон эмнэлзүй, тархварзүйн сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх чиглэлээр өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, гүйцэтгэл, чанар, аюулгүй байдлын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллана.

ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ ХЯНАЛТЫН ҮҮРЭГ

1. Халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр мөрдөгдөж буй тушаал, журам, заарын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил аргазүйн зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлнэ.
2. Амьсгалын замын халдварын шалтгаантай эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын дэгдэлт гарсан болон халдвар гарах эрсдэл бий болсон үед хариу арга хэмжээг холбогдох тушаал, журмын дагуу шуурхай авч хэрэгжүүлнэ.
3. Эрүүл мэндийн байгууллага дээр эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын дэгдэлт гарсан болон халдвар гарах эрсдэл бий болсон үед очиж, идэвхтэй тандалт хийн, эрсдэлт хүчин зүйлийг тогтоож, таслан зогсоох арга хэмжээг авна.
4. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар (ЭТҮХХ)-аас сэргийлэх чиглэлээр эмч, эмнэлгийн ажилтанд сургалт зохион байгуулна.
5. Эрүүл мэндийн байгууллага дээр Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед халдварын сэргийлэлт, хяналтын арга хэмжээний тасралтгүй байдлыг хангуулах, шаардлагатай нөөцийн бүрдүүлэлтийг хийхэд дэмжлэг үзүүлнэ.
6. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын идэвхтэй болон идэвхгүй тандалт, судалгааг эрүүл мэндийн байгууллагууд дээр тогтмол хийж, тоон мэдээнд дүн шинжилгээ хийн Хариу арга хэмжээний багийн даргад тухай бүрт тайлагнана.

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2024 оны 11 дугаар сарын 19-ны өдрийн
1192 дугаар тушаалын 17 хавсралт



ТӨЛӨВЛӨЛТИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар
Багийн ахлагч	Г.Адьяа	ЭТҮЭО дарга	95079900
Гишүүд	Б.Халиунгэрэл	Сувилахуйн албаны дарга	94046363
	Б.Түвшинжаргал	Мэдээлэл технологийн ажилтан	80069005
	Д.Дэлгэрцэцэг	Статистикч эмч	89063689
	Л.Дуламсүрэн	Архив, бичиг хэргийн ажилтан	99590144

ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮҮРЭГ

1. Төлөвлөлт хийхэд шаардлагатай бүх төрлийн мэдээллийг холбогдох багууд болон тасаг нэгжүүдээс авна.
2. Томуу, томуу төст өвчин, Амьсгалын замын цочмог хүнд халдварын өвчлөлийн мэдээ, авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ, нөөц, санхүүжилт зэрэг холбогдох мэдээллийг мэргэжлийн багуудаас авч нэгтгэн, хариу арга хэмжээний нэгдсэн тайлан бэлтгэж, төлөвлөлтийн багийн даргад танилцуулна.
3. Мэдээ, мэдээлэл авах журам, заавар, хүснэгт, маягтыг боловсруулан төлөвлөлтийн багийн даргаар батлуулж, мэргэжлийн багуудад хүргүүлнэ.
4. Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай, заавар, журам, түр заавар, албан даалгавар зэрэг бодлогын болон техникийн баримт бичгийг бүртгэж, архивлана.
5. Хариу арга хэмжээний тайлан, мэдээг бүртгэж, архивлана.
6. Санхүү, ложистик, нөөцийн багаас нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалтын мэдээг авч архивлана.

САНХҮҮ, ЛОЖИСТИК, НӨӨЦ ЗОХИЦУУЛАЛТЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар
Багийн ахлагч	Т.Булгантамир	Стратеги бодлого төлөвлөлтийн албаны дарга	99102909
Гишүүд	С.Хурц	Хүний нөөцийн менежер	86080055
	Б.Даваадэмбэрэл	Эм зүйн албаны дарга	88011377
	Э.Тамир	Хангамж хариуцсан менежер	88016599
	Б.Мягмарсүрэн	Ерөнхий нягтлан	99451117

1. Томуу, томуу төст өвчин, Амьсгалын замын цочмог хүнд халдварын дэгдэлтийн үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас, ариутгал халдваргүйтгэлийн бодис, урвалж оношлуурын нөөцийн судалгаа гаргаж, татан авалтыг хийж бэлэн байдлыг хангана.
2. Мэргэжлийн багуудын мэргэжилтнүүдийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
3. Шаардлагатай үед ажиллах хүний нөөцийн судалгааг гаргаж бэлэн байдлыг хангана.
4. Шаардлагатай үед нэмж дэлгэх орны нөөцийн судалгаа гаргаж бэлэн байдлыг хангуулна.
5. Дайчлагдан ажиллаж байгаа хүний нөөцийн илүү цагийн цалин хөлс болон шаардлагатай нөөцийн санхүүжилтийг шийдвэрлэнэ.
6. Санхүүгийн орлого, зарлагын тайланг заасан хугацаанд тохиолдлын удирдлагын багийн даргад танилцуулна.